



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2009 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 211

Улаанбаатар хот

“Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 13.1.3, 14.2.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ журмыг 2010 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Тогтоол батлагдсантай холбогдуулан “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам” батлах тухай Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 66 дугаар тогтоолыг энэ тогтоолын 1-д заасан журам үйлчилж эхэлмэгц хүчингүй болсонд тооцсугай.

4. Батлагдсан журмын биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийн талаар 2010 оны 1 дүгээр улиралд багтаан Хорооны хуралдаанд танилцуулж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ЕРДИЙН ДААТГАГЧИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫГ ТООЦОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Даатгалын тухай хуулийн 14.2.2 дахь заалтыг хэрэгжүүлэхэд энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг компани (цаашид “даатгагч” гэх) нь даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгөтэй байвал зохино.

Хоёр. Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт

2.1. Даатгагчийн төлбөрийн чадварын байдлыг тодорхойлохдоо төлбөрийн чадварын зохистой харьцаа, төлбөрийн чадварын хязгаар гэсэн 2 үзүүлэлтээр тооцно.

2.2. “Төлбөрийн чадварын зохистой харьцаа”-г тооцохдоо даатгагчийн зөвшөөрөгдөх хөрөнгийн дүнг өр төлбөрийн дүнд харьцуулж хувиар илэрхийлж тогтооно. (Төлбөрийн чадварын зохистой харьцаа= $\frac{\text{Зөвшөөрөгдөх хөрөнгийн дүн}}{\text{Өр төлбөрийн дүн}} \cdot 100\%$)

2.2.1. Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 125 хувь буюу түүнээс илүү байна.

2.2.2. Хэрэв даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа 100-125 хувийн хооронд байвал даатгагч төлбөрийн чадваргүй болж болзошгүйд тооцно.

2.2.3. Хэрэв даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа 100 хувиас доош байвал даатгагчийг төлбөрийн чадваргүй болсонд тооцно.

2.3. “Төлбөрийн чадварын хязгаар”-ыг тооцохдоо даатгагчийн зөвшөөрөгдөх хөрөнгийн дүнгээс өр төлбөрийн дүнг хасаж тогтооно. (Төлбөрийн чадварын хязгаар= $\frac{\text{Зөвшөөрөгдөх хөрөнгийн дүн}}{\text{Өр төлбөрийн дүн}}$):

2.3.1. Даатгагчийн төлбөрийн чадварын хязгаар нь даатгагчид зайлшгүй байх хөрөнгийн хэмжээтэй тэнцүү буюу түүнээс илүү байна.

2.4. Хэрэв даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа болон төлбөрийн чадварын хязгаарын аль нэг нь шаардлага хангаагүй бол тухайн даатгагчийг төлбөрийн чадваргүй болсонд тооцно.

2.5. Төлбөрийн чадварын хязгаар нь 2.7-д дурдсан шаардлагыг хангасан хэдий ч төлбөрийн чадварын зохистой харьцаа 2.4-т заасан төлбөрийн чадваргүй болж болзошгүй болсон тохиолдолд тухайн даатгагчийг төлбөрийн чадваргүй болж болзошгүйд тооцно.

2.6. Даатгагчид зайлшгүй байх хөрөнгийн хэмжээг тооцохдоо дараах 3 үзүүлэлтийн хамгийн их дүнг үндэслэн тогтооно:

2.6.1. Агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн орлогод тооцсон хураамжийн 40 хувь дээр бусад даатгалын хэлбэрийн орлогод тооцсон хураамжийн 20 хувийг нэмсэн дүн;

2.6.2. Агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн сүүлийн 3 жилд нэхэмжилсэн хохирлын дундаж дүнгийн 50 хувь дээр бусад хэлбэрийн сүүлийн 3 жилд нэхэмжилсэн хохирлын дундаж дүнгийн 20 хувийг нэмсэн дүн;

2.6.3. Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон дүрмийн сангийн (хувь нийлүүлсэн хөрөнгийн) доод хэмжээ.

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 140 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/

2.7. Энэхүү журмын 2.10.2-т заасан нэхэмжилсэн хохирлын дүнг гаргахдаа тухайн жилд олгосон нийт нөхөн төлбөрийн дүн дээр нэхэмжилсэн боловч олгоогүй хохирлын дүнг нэмж тооцно.

Гурав. Зөвшөөрөгдөх хөрөнгө ба өр төлбөр

3.1. Даатгагчийн зөвшөөрөгдөх хөрөнгө нь компанийн нийт хөрөнгийн дүнгээс зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүнг хассанаар тодорхойлогдоно. (Зөвшөөрөгдөх хөрөнгө= Нийт хөрөнгө-Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө).

3.2. Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө гэж даатгагчийн төлбөрийн чадварын үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж болохуйц хөрөнгүүдийг хэлнэ.

3.3. Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүнг дор дурдсан хөрөнгийн заагдсан хувиар тооцож тогтооно:

3.3.1. Бэлэн мөнгө, Банкны харилцах, хадгаламж, хадгаламжийн сертификат, Засгийн газрын бонд, Төв банкны үнэт цаас - 0 хувь

3.3.2. 180 хоногоос доошхи хугацаатай авлага - 0 хувь

~~3.3.3. Буруутай этгээдээр төлүүлсэн нөхөн төлбөр болон даатгагчийн авсан даатгуулагчийн сүйрсэн хөрөнгө (Salvage and Subrogation) - 0 хувь.~~

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 140 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон/

3.3.4 Санхүүгийн болон үйл ажиллагааны лизинг - 5 хувь

3.3.5. Үл хөдлөх хөрөнгө - 5 хувь

3.3.6. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас – 5 хувь

3.3.7. Даатгалын тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан холбогдох этгээдээс бусад этгээдэд үл хөдлөх хөрөнгө барьцаалсан богино хугацаат зээл - 8 хувь

3.3.8. Орон нутгийн засаг захиргааны бонд - 10 хувь

3.3.9. Компанийн бонд - 10 хувь

3.3.10. Эд хогшил, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж - 95 хувь

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 140 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан/

3.3.11. 180 хоногоос дээш хугацаанд төлөгдөөгүй байгаа авлага - 100 хувь

3.3.12. Биет бус хөрөнгө - 100 хувь

3.3.13. Бараа материал - 100 хувь

3.3.14. Урьдчилж төлсөн зардал - 100 хувь

3.3.15. Бусад хөрөнгө (Даатгагчийн хөрөнгийн 3.3.1-3.3.14-т зааснаас бусад хөрөнгө) - 100 хувь.

3.4. “Өр төлбөр” гэж тайлант хугацааны богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөрийн нийлбэр дүнг хэлнэ. Өр төлбөрийг тооцохдоо богино хугацаат өр төлбөрийн хэсэг дэх орлогод тооцоогүй хураамжийн орлогыг 10 хувиар бууруулна.

Дөрөв. Хяналт тавих

4.1. Энэ журмын хэрэгжилтэнд Хороо байнгын хяналт тавина.

4.2. Энэ журмын хавсралтаар батлагдсан тайлангийн маягтын дагуу даатгагчийн төлбөрийн чадварын байдлыг тооцно.

4.3. Даатгагч төлбөрийн чадварын тайланг улирал бүр гарган санхүүгийн тайлангийн хамт Хороонд ирүүлнэ.

4.4. Энэ журамд заасны дагуу даатгагч төлбөрийн чадваргүй болж болзошгүй, эсвэл төлбөрийн чадваргүй болсон бол энэ талаар Хороонд нэн даруй мэдэгдэнэ.

4.5. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

“Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”-ын хавсралт

..... ХХК-ийн оны дүгээр улирлын төлбөрийн чадварын үзүүлэлт
/мянган төгрөгөөр/

1. Зайлшгүй байх хөрөнгө / $1 = \max(1.1, 1.2, 1.3)$ /				0.0
Үзүүлэлт		Дүн	Тооцох хувь	Тооцсон дүн
1		2	3	4
1.1 Даатгалын хураамжид үндэслэх /Тухайн тайлант хугацааны нийт орлогод тооцсон хураамж / (1.1.1 (4)+1.1.2 (4))				0.0
1.1.1	Агаарын хөлөг, авто тээврийн хэрэгсэл, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн орлогод тооцсон хураамж	0.0	40%	0.0
1.1.2	Бусад хэлбэрийн орлогод тооцсон хураамжийн 20%	0.0	20%	0.0
1.2 Даатгалын нэхэмжлэлд үндэслэх /Сүүлийн 3 жилийн дунджид үндэслэн/ (1.2.1 (4)+1.2.2 (4))				0.0
1.2.1	Агаарын хөлөг, авто тээврийн хэрэгсэл, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн нөхөн төлбөр * 50%	0	50%	0.0
1.2.2	Бусад хэлбэрийн нөхөн төлбөр * 20%	0	20%	0.0
1.3 Дүрмийн санд үндэслэх				0.0
2. Нийт хөрөнгө				0.0
		Дүн	Бууруулах хувь	Тохиргоо хийгдсэн дүн
3. Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө (3.1(4) :3.14(4))				0.0
3.1	Бэлэн мөнгө, Банкны харилцах, хадгаламж, хадгаламжийн сертификат, Засгийн газрын бонд, Төв банкны үнэт цаас	0.0	0%	0.0
3.2	180 хоногоос доошхи хугацаатай авлага	0.0	0%	0.0
3.3	Буруутай этгээдээр төлүүлсэн нөхөн төлбөр болон даатгагчийн авсан даатгуулагчийн сүйрсэн хөрөнгө (Salvage and Subrogation)	0.0	0%	0.0
3.4	Санхүүгийн болон үйл ажиллагааны лизинг	0.0	5%	0.0
3.5	Үл хөдлөх хөрөнгө	0.0	5%	0.0
3.6	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	0.0	5%	0.0
3.7	Холбогдох этгээдээс бусад этгээдэд үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан богино хугацаат зээл	0.0	8%	0.0
3.8	Орон нутгийн засаг захиргааны бонд	0.0	10%	0.0
3.9	Компанийн бонд	0.0	10%	0.0
3.10	Эд хогшил тоног төхөөрөмж	0.0	95%	0.0
3.11	Бусад авлага	0.0	100%	0.0
3.12	Биет бус хөрөнгө	0.0	100%	0.0
3.13	Бараа материал	0.0	100%	0.0
3.14	Урьдчилж төлсөн зардал	0.0	100%	0.0

3.15 Бусад хөрөнгө	0.0	100%	0.0
4. Зөвшөөрөгдөх хөрөнгө / $4=(2)-(3)/$			#REF!
5. Өр төлбөр / $5=урт хугацаат өр төлбөр+богино хугацаат өр төлбөр-ОТХ*10\%/$			0.0
6. Төлбөрийн чадварын зохистой харьцаа / $6=(4)/(5)\geq 125 /$			#REF!
7. Төлбөрийн чадварын хязгаар / $7=(4)-(5)\geq(1) /$			#REF!